



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/З.25

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Осол гэмтлээс урьдчилан үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, осол гэмтлийн үеийн яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай яс үе мөчний хагалгааны олон үйлдэлт багаж тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд 6000 000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 6000 000 төгрөг /Зургаан сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.12 дахь заалтын "Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах" төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ